



**СЭЛЭНГЭ АЙМАГ  
ОРХОНТУУЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 21

Баянцогт


**Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2017-2020 оны стратеги төлөвлөгөө  
батлах тухай**

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасныг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5-р хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү төлөвлөгөөг жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, хэрэгжилт үр дүнг тайлагнаж байхыг сумын ИТХ-ын ажлын алба /О.Мөнхцэцэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА



М.ЦОГБАЯР



## **ОРХОНТУУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2017-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **1. АЛСЫН ХАРАА**

Иргэний оролцоог дээдэлсэн Нутгийн өөрөө удирдах байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлснээр Орхонтуул сайхан нутгаа “Улсын Тэргүүний сум” болгоно.

### **2. ЭРХЭМ ЗОРИЛГО**

Нутгийн өөрөө удирдах байгууллагын ажлын үр нөлөө, чанар хүртээмжийг дээшлүүлж, чадварлаг, нээлттэй, ил тод болгон төлөвшүүлж иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд тулгуурлан орон нутгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх тасралтгүй үйл ажиллагаатай сумын ард иргэдийн аж амьдралыг дээшлүүлэх, ая тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх бодлого шийдвэрийг орон нутгийн онцлогт тохируулан батлан гаргаж хэрэгжилтийг хангуулан ажиллахад эрхэм зорилго оршино.

### **3. ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ**

#### *1. Ил тод нээлттэй байх зарчим.*

Аливаа явуулж байгаа үйл ажиллагаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь олон түмний дунд ил тод, нээлттэй хэрэгжиж байх

#### *2. Шударга ёсны зарчим*

ИТХ нь бүхий л үйл ажиллагаандаа голч шударга, аливаа үзэл суртлаас ангид байх зарчим баримтлах

#### *3. Найдвартай хүртээмжтэй байх зарчим.*

ИТХ-аас зохион байгуулж явуулсан үйл ажиллагаа нь иргэдийн хэрэгцээ, сонирхлыг хангахуйц хүртээмж чанар сайтай байх

#### *4. Бие даасан байх зарчим*

ИТХ нь зохион байгуулалт, удирдлагын хувьд төрийн захиргааны удирдлагаас тусгаар байж, орон нутгийн чанартай асуудлуудыг бие даан шийдвэрлэж байх

#### *5. Хамтын зарчим.*

ИТХ-аас гарсан аливаа шийдвэр нь нутаг дэвсгэр, иргэд сонгогчдын тоо, эрх ашиг сонирхолд нийцсэн төлөөлөгчдийн хамтын шийдвэр байх

#### *6. Хариуцлагатай байх зарчим.*

Монгол Улсын хууль тогтоомжийг сахин биелүүлж хууль дээдлэх үйл ажиллагаанд оролцогчдын "эрх, үүрэг, хариуцлагын" нэгдлийг ханган, нийгмийн дэг журмыг хэрэгжүүлэх, төлөөлөгч бүр сонгосон иргэд сонгогчдынхоо өмнө хариуцлага хүлээдэг байх.

#### **4. СТРАТЕГИ ЗОРИЛТУУД, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Монгол Улсын Үндсэн хууль, Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд 2017-2020 онд баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг энэхүү стратеги төлөвлөгөөгөөр тодорхойлж байна.

**Стратеги зорилт 1: Нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоо, харилцаа нэгдлийг хангаж, ИТХ-ын үйл ажиллагааны чадавхи, дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах.**

##### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 1.1. Сумын ИТХ-ын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааны дэг, ИТХ-ын ажилд мөрдөх дүрэм, журмыг шинэчлэн мөрдөх
- 1.2. ИТХ-ын төлөөлөгчидтэй ажиллах, тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэн ажлыг дүгнэж урамшуулах, төлөөлөгчдийн өдрийг зохион байгуулах
- 1.3. ИТХ-ын дэргэдэх бодлогын хороодын ажлыг тогтмолжуулах, хяналт шалгалт хийх, хуралдаанд дүгнэлт оруулах зэргээр ажлын арга барилыг сайжруулан хийсэн ажлын үр дүнгээр урамшуулах ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх
- 1.4. ИТХ-ын төлөөлөгчдийг тойрог бүрт нь өөрийн харъяалах оршин суугаа багт нь баг болгон иргэд сонгогчидтой уулзалт хийх, Хурлын шийдвэрийг сурталчлан иргэдийн санал хүсэлтийг барагдуулах
- 1.5. Сумын ИТХ-ын ажлыг бэхжүүлэхэд дарга, нарийн бичгийн дарга нар ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдааны бэлтгэл, хурлын шийдвэр, хуулийн биелэлт, хяналт шалгалтын ажил, хурлын төсөв санхүүгийн асуудал, бичиг хэрэг, архив лавлагаа, ИНХ-д мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, иргэдтэй харилцах, сургалт зөвлөгөөн зэрэг ажлыг зохион байгуулах
- 1.6. Сумын ИТХ-ын ажлын албаны орон тоог ажлын ачаалал, шаардлагыг харгалзан шинэчлэн тогтоох, машин унаатай болгох асуудлыг шийдвэрлүүлэх.
- 1.7. Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол, санаа бодлыг судлах, орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавихад иргэдийн оролцоог өргөтгөх
- 1.8. Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн өдрүүдийг тодорхой удирдамж боловсруулан тогтмол хугацаанд зохион байгуулж ИТХ-ын үйл ажиллагаа, шийдвэр бодлогыг сурталчлан иргэд сонгогчидтой ажиллах нөхцлийг бүрдүүлэн Хурал – орон нутаг – иргэд – хурал гэсэн эргэх холбоо тогтоож ажиллах
- 1.9. Сумын Хурлын ажлыг олон нийтэд нээлттэй болгох, шийдвэр гаргалтанд иргэдийн дуу хоолой санал бодлыг тусгах, иргэдийн санал эрэлт хүсэлтийг төр засгийн байгууллагад уламжлан шийдүүлэх замаар төрийн хэргийг удирдахад иргэдийн бүтээлч оролцоог өргөжүүлэх

**Стратеги зорилт 2: Хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн боловсруулалтын шинжлэх ухааны болон эдийн засаг, эрхзүйн үндэслэлийг сайжруулах.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 2.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн төслийн эдийн засгийн тооцоо судалгааг тухайн асуудал хариуцсан мэргэжлийн хэлтэс газруудаар хийлгэх.
- 2.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргах шийдвэрийн эдийн засаг, нийгмийн эерэг, сөрөг үр дагаврыг тооцож харгалзан шийдвэрлэх.
- 2.3. Орон нутаг, иргэдийн эрх ашгийг хөндсөн асуудал шийдвэрийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах ажлыг зохион байгуулах.
- 2.4. Хэлэлцэх асуудал, шийдвэрийн төслийг Хурлын Тэргүүлэгч, Төлөөлөгч, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулан хянан боловсруулж сайжруулах.
- 2.5. Тухайн хэлэлцэх асуудал, холбогдох хууль тогтоомжийг хурлын тэргүүлэгч, төлөөлөгчдөд судлуулах, тайлбарлан ойлгуулах, бодлогын хороогоор хэлэлцүүлэх зэргээр урьдчилан сайтар бэлтгэж, гаргах шийдвэрийг хууль, тогтоомжид нийцүүлэн гаргах.

**Стратеги зорилт 3: Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн биелэлтийн явцыг хянан шалгах, үр дүнг тооцох ажлыг сайжруулах.**

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

- 3.1. Сумын ИТХ-ын тогтоол шийдвэрийн биелэлтийн тухай мэдээллийг Тэргүүлэгчдийн хуралдаанаар жил бүр хэлэлцэн дүгнэлт хийж байх.
- 3.2. Сумын ИТХ, түүний Тэргүүлэгчдээс батлан гаргасан доорх бодлого шийдвэрүүдийн биелэлтийн явц, үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх.
  - 3.2.1. Хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх хөтөлбөр
  - 3.2.2. Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар дэд хөтөлбөр
  - 3.2.3. ХАА болон бусад салбараас төрийн дээд одон медалиар шагнагдсан, Улсын болон аймаг, сумын аваргаар шалгарсан иргэн, ААН-д сумаас олгох шагналын хэмжээг тогтоох тухай журам
  - 3.2.4. Ахмад настанд тусламж хөнгөлөлт үзүүлэх журам
  - 3.2.5. Шинээр төрсөн эх хүүхдэд хүндэтгэл үзүүлэх журам
  - 3.2.6. Архигүй Орхонтуулчууд сумын хөтөлбөр
  - 3.2.7. Оюутны тэтгэлэгт хөтөлбөр
  - 3.2.8. Сайн үйлсийн хөтөлбөр
  - 3.2.9. Амьдралын төгөл хөтөлбөр
  - 3.2.10. Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр
  - 3.2.11. Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөр
  - 3.2.12. Өсвөр үе, хүүхэд залуусын хүмүүжил, хөгжлийг дэмжих хөтөлбөр
  - 3.2.13. Сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам
- 3.3. Хурлын тогтоол шийдвэрийн биелэлтэд хурлын Тэргүүлэгчид, бодлогын хороо, ажлын хэсгийн хяналт шалгалтыг тогтмолжуулах.

**Стратеги зорилт 4: Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар сумын эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж бодлого зорилтыг тодорхойлох.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

**4.1. Сумын ИТХ-ын хуралдаанаар доорх асуудлуудыг хэлэлцэн бодлогын шийдвэр гаргах.**

4.1.1. Ахуйн үйлчилгээний хөгжлийг дэмжих сумын хөтөлбөр

4.1.2. Багийн Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарын ажлыг дүгнэж урамшуулал олгох журам батлах

**4.2. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан доорх хөтөлбөр, журмуудыг хэлэлцэн батлах.**

4.2.1. “Соёлч өрх” шалгаруулах журам

4.2.2. Орхонтуул сумын нутагт Нохой тэжээх, арчлах, золбин нохой устгахад дагаж мөрдөх журам

4.3. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлийг хэлэлцэн баталж тухайн жилд онцлох зорилтыг тодорхойлж биелэлтийн явцад хяналт тавьж гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж байх.

**Стратеги зорилт 5. Сумын төсвийн орлогыг нэмэгдүүлэн санхүүгийн чадавхийг сайжруулах, орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалтыг бэхжүүлэн төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, Сум хөгжүүлэх сан, Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажил, төсөл арга хэмжээний чанар, үр дүн, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээг оновчтой тогтоон баталж, хэрэгжилтийг хангуулах

5.2. Сумын төсвийн орлого зарлага, зарцуулалтад Хурлаас тавих хяналтыг сайжруулах

5.3. Сумын төсвийн боловсруулалт, хуваарилалтыг бодитой тооцож үндэслэлийг сайжруулах, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд хурлаас тавих хяналтыг тогтмолжуулах.

5.4. Орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалтыг бэхжүүлж, өмчийн бүртгэл тооцоо, хяналт, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах.

5.5. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг иргэд, олон нийтийн нээлттэй санал асуулгаар багийн ИНХ-аар хэлэлцүүлэн тодруулж ач холбогдлоор нь эрэмбэлэн сонгож шийдвэрлэх.

5.6. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр олгогдсон зээлийн эргэн төлөлтийг сайжруулан суманд нэн шаардлагатай байгаа тэргүүлэх чиглэлээр тодорхойлогдсон ахуй үйлчилгээг хөгжүүлэх арга хэмжээнд зарцуулан хэрэгжилтийг хангуулан ажиллах

**Стратеги зорилт 6: Нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн иргэдийн амгалан тайван аюулгүй ажиллаж амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэхэд нутгийн захиргаа, хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэн, иргэд олон нийтийн оролцоог сайжруулах.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 6.1. Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан нийтэд мэдээлж түүнийг арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог хангах.
- 6.2. Сум багт хэв журмын олон нийтийн байцаагчийн тоог нэмэгдүүлэх талаар уламжилж, олон нийтийн эргүүл жижүүрийг иргэдийн өөрсдийн үүсэл санаачилгаар, зохион байгуулах.
- 6.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэн мал хулгайлах гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сумын "Малчдын зөвлөл"-тэй хамтарч ажиллах
- 6.4. Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулан удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах
- 6.5. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сумын дэд хөтөлбөрийг орон нутгийн түвшинд боловсруулан баталж, хэрэгжилтийг хангуулан ажиллах

**Стратеги зорилт 7: Байгаль орчныг хамгаалах ажлыг хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг хязгаарлан бууруулах, нөхөн сэргээх замаар хүн амын эрүүл мэнд, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд чиглүүлэх.**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- 7.1. Байгаль орчныг хамгаалах талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт хурлын шийдвэрийн биелэлтэд хурлаас тавих хяналтыг сайжруулах.
- 7.2. Төв суурин газрын ахуйн хог хаягдлыг цэвэрлэх цуглуулах, тээвэрлэх, ангилах, ялгах, дахин боловсруулах, булшлах ажлыг хариуцан гүйцэтгэх, эзэнтэй болгож хөрөнгө, техникийн дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргах
- 7.3. Байгалийн төрөл зүйл амьтан, ой ургамал, гол горхи, уст цэг, үйл ажиллагаанд өртөж эвдэрч элэгдсэн талбай, байгаль орчныг бохирдуулагч эх үүсвэр зэргийн тооллого судалгааг жил бүр ээлж дараатай хийж дүгнэлт гарган, авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.
- 7.4. Сумын ИТХ-аас баталсан "Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх", "Амьдралын төгөл" хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлыг бодлого зохицуулалтаар хангах

## **5.ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ЗАРИМ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

1. Энэхүү төлөвлөгөөг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.
2. Сумын ИТХ-ын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад ИТХ-ын дэргэдэх бодлогын хороод идэвхтэй оролцож тухайн чиглэлээр бодлого боловсруулан хэрэгжүүлж биелэлтэнд нь хяналт тавьж, тайлагнана.
3. Стратеги төлөвлөгөөний зорилтыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.